



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/246

Улаанбаатар хот

Г Журам шинэчлэн батлах тухай Г

Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 3.6, 3.7, 3.8, 5.5, 5.8 дахь заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-д эрдэм шинжилгээний ажилтан ажиллуулах журам"-ын шинэчилсэн "МУИС-д судлаач ажиллуулах журам"-ын найруулгыг хавсралтаар баталж, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Тушаал батлагдсантай холбогдуулан МУИС-ийн захирлын 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/490 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээний хэлтсийн дарга (С.Должин), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ОЧИРХУЯГ

Захирлын 2022 оны 04 дугаар сарын 01-ны
өдрийн 4/246 дугаар тушаалын хавсралт



МУИС-Д СУДЛААЧ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг зүйл

1.1. Энэхүү журам нь МУИС-д шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, төсөл, хөтөлбөрийн хүрээнд судлаач ажиллуулах; сургалт, судалгаа, боловсруулалт, инновацийн ажлын нэгдлийг хангах; инновацийн тогтолцоонд шаардлагатай мэдлэг, хүний нөөцийг буй болгох зэрэг үйл ажиллагаа, харилцааг “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Иргэний хууль”, “МУИС-ийн 2016-2024 оны стратегийн төлөвлөгөө”, “Монгол Улсын Засгийн газрын тогтоол” (2018 оны 282 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх” үндэсний хөтөлбөр, 2019 оны 328 дугаар тогтоолын хавсралт), “МУИС-ийн дүрэм”, “МУИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам”, “МУИС-д ажилтан ажиллуулах журам”-д нийцүүлэн зохицуулна.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. “Судлаач” гэж шинэ мэдлэг, онол арга зүй, практик хэрэглээ, инновацийн бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны үндэслэл, нотолгоотойгоор бий болгох шинжлэн судлах, хөгжүүлэх, турших, магадлан шалгах, хэрэгжүүлэн нэвтрүүлэхэд чиглэсэн суурь, хэрэглээний судалгаа, туршилт боловсруулалтын үйл ажиллагаа хэрэгжүүлж буй иргэнийг;

1.2.2. “Бүтэн цагаар ажилласан хүний тоонд шилжүүлсэн утга (цаашид “БЦАХТШУ” гэх)” гэж судалгааны хүний нөөцийн бодит хэмжээ буюу судлаачийн эрдэм шинжилгээний ажлын ачааллыг илэрхийлсэн хүн- жилийг.

ХОЁР. МУИС-д судлаачаар ажиллуулах хэлбэр, түүнд тавигдах шаардлага

2.1. МУИС-ийн судлаачийг санхүүжиж буй эх үүсвэрээс нь хамааран дараах хэлбэрээр ажиллуулна. Үүнд:

2.1.1. Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан МУИС-ийн харьяа эрдэм шинжилгээний төв, хүрээлэнд ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан(цаашид “ЭША” гэх);

2.1.2. МУИС-ийн санхүүжилттэй судлаачийг дараах хэлбэрээр ажиллуулна. Үүнд:

2.1.2.1. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач;

2.1.2.2. “МУИС-д пост-доктор ажиллуулах журам”-ын 2-р зүйлд дурдсан докторын дараах судлаач;

2.1.2.3. “МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам”-ын 2.1.1-д дурдсан судалгааны туслах ажилтан.

2.1.3. ШУТС, төрийн байгууллага, олон улсын байгууллага, аж үйлдвэр, компани, мөн хувь хүний санхүүжилт зэрэг МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн удирдагч болон гүйцэтгэгч гишүүн (цаашид “МУИС-иас өөр санхүүжилттэй судлаач” гэх)

2.2. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач, докторын дараах судлаач, мөн МУИС-иас өөр санхүүжилттэй судлаач нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. шинжлэх ухаан, технологийн судалгаа, боловсруулалт, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх чадвартай байх;

2.2.2. шинжлэх ухааны ёс зүй, оюуны өндөр соёл, зан төлөвшилтэй байх;

2.2.3. судалгааны шинэ чиглэл санаачлах, хэрэгжүүлэх туршлагатай байх;

2.2.4. шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил, эрдэм шинжилгээний хурал, семинар удирдах арга барил эзэмшиж, багаар ажиллах чадвартай байх;

2.2.5. судалгааны арга зүй эзэмшсэн, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн төлөө байнга санаачлагатай ажилладаг байх;

2.2.6. англи хэлийг мэргэжлийн түвшинд эзэмшсэн байх.

2.3. Судалгааны туслах ажилтан нь “МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам”-ын 2-р зүйлд дурдсан шаардлагыг хангасан байна.

ГУРАВ. МУИС-д судлаач ажилд авах

3.1. ЭША-г холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу сонгон шалгаруулна.

3.2. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаачийн сонгон шалгаруулалтыг хичээлийн жилд 1-2 удаа зохион байгуулна.

3.3. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаачийн хүний нөөцийн төлөвлөгөө, төсвийг Захиргаа, хүний нөөц хариуцсан (цаашид “ЗХНХ” гэх) нэгж, Эрдэм шинжилгээ хариуцсан (цаашид “ЭШХ” гэх) нэгж, Санхүү төлөвлөлт хариуцсан (цаашид “СТХ” гэх) нэгж 2 жил тутам хамтран боловсруулж МУИС-ийн захирлаар батлуулна.

3.4. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаачаар энэхүү журмын 2.2-д дурдсан тусгай шаардлагыг хангасан иргэнийг “МУИС-д ажилтан ажиллуулах журам”-ын 5-р зүйлд заасан зохицуулалтад үндэслэн ажиллуулна. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач нь судалгааны хүрээлэн, төвийн захиралтай Хөлсөөр ажиллах гэрээ байгуулна.

3.5. МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаачаар энэхүү журмын 2.2-д дурдсан тусгай шаардлагыг хангасан иргэнийг “МУИС-д зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журмын”-ын 3.4, 4.3, 5.1-д заасан зохицуулалтад үндэслэн ажиллуулна. МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаач төслийн удирдагчтай Хөлсөөр ажиллах гэрээ байгуулна.

3.6. Докторын дараах судлаачийг “МУИС-д пост-доктор ажиллуулах журам”-ын 3-р зүйлд заасны дагуу ажиллуулна.

3.7. Судалгааны туслах ажилтанг “МУИС-ийн магистрант докторантыг туслахаар ажиллуулах журам”-ын 3-р зүйлд заасны дагуу ажиллуулна.

3.8. Судлаачийн шаардлагыг бүрэн хангасан иргэнийг судалгааны ажлын хамрах хүрээ, ажлын шаардлагаас хамааран 10 сар хүртэлх хугацаагаар Хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулна.

3.9. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач, МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаач нь улирал, хагас жил болон хичээлийн жилээр гүйцэтгэлийн үр дүнг судалгааны хүрээлэн, төв, төслийн удирдагчид тайлагнана.

3.10. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач, мөн МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаачийн судалгааны ажлын үр дүнг хичээлийн жил бүр 06 дугаар сарын 15-ны дотор дүгнэнэ.

3.11. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаачийг “МУИС-д судалгааны хүрээлэн, төвийн үйл ажиллагааны журам”-ын 4.2.4-р зүйлд заасны дагуу дүгнэнэ.

3.12. Докторын дараах судлаачийн судалгааны ажлын явц, үр дүнг “МУИС-д пост-доктор ажиллуулах журам”-ын 6-р зүйлд заасны дагуу хичээлийн жилийн улирал бүр дүгнэнэ.

3.13. Судалгааны туслах ажилтныг “МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам”-ын 5-р зүйлд заасны дагуу хичээлийн жилийн улирал бүр дүгнэнэ.

ДӨРӨВ. МУИС-ийн судлаачийн эрх, үүрэг

4.1. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач, докторын дараах судлаач, мөн МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаач нь дараах эрх эдэлнэ. Үүнд:

4.1.1. төсөл боловсруулахад оролцох;

4.1.2. бакалавр ба түүнээс дээш зэргийн суралцагчийн судалгааны ажил удирдах;

4.1.3. судалгааны үр дүнг хэлэлцүүлэх;

4.1.4. тухайн ажлын гүйцэтгэл, явцын талаарх санал гаргах;

4.1.5. ажлын гүйцэтгэлийг үнэлүүлэн хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн даатгал, бусад албан татварыг төлүүлэх;

4.1.6. гэрээний хугацаа дууссан, өвчний улмаас ажил гүйцэтгэх чадваргүй болсон зэрэг хүндэтгэх шалтгаан, хуульд заасан бусад үндэслэлтэй тохиолдолд Хөлсөөр ажиллах гэрээг дуусгавар болгох;

4.1.7. төслийн үйл ажиллагааны талаар зохион байгуулалтын туслалцаа авах, харилцан зөвшилцөх.

4.2. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаач, докторын дараах судлаач, мөн МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаач нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:


4.2.1. патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан эсвэл олон улсын мэргэжлийн магадлагаа бүхий сэтгүүлд сүүлийн гурван жилд нэгээс доошгүй өгүүлэл хэвлүүлсэн байх;

4.2.2. байгууллагын дотоод дүрэм журмыг ажиллах хугацаандаа дагаж мөрдөх;

- 4.2.3. байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол, хэвийн үйл ажиллагааны горим, нэр хүндэд харш, сөргөөр нөлөөлж болох зөрчил гаргахгүй байх;
- 4.2.4. хүлээн авсан эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг ариг гамтай хэрэглэх, албаны бичиг баримтын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах;
- 4.2.5. бусад байгууллагын судалгааны ажлыг гүйцэтгэхэд МУИС-ийн эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн эд хөрөнгийг ашиглахгүй байх;
- 4.2.6. ажил үүргийг гүйцэтгэхэд ашигласан өгөгдөл, мэдээлэл, материалыг чандлан хамгаалж, задруулахгүй байх;
- 4.2.7. оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбоотой өгөгдөл, биет бус хөрөнгийг бусдад шилжүүлэх, түгээх, задруулахгүй байх;
- 4.2.8. судалгааны төслийн үр дүнг судалгааны хүрээлэн, төв, төслийн удирдагчид тайлагнах;
- 4.3. МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн удирдагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 4.3.1. судалгааны санхүүжилтээр хоёроос доошгүй судлаач ажиллуулдаг байх;
- 4.3.2. бакалавр ба түүнээс дээш зэргийн суралцагчийн судалгааны тэтгэлэг, урамшууллыг төсөвлөсөн байх;
- 4.3.3. санхүүжилт МУИС-ийн дансаар шилжин орсон байх;
- 4.3.4. “Судалгааны санхүүжилтээс МУИС-д шууд бус зардлын хуримтлал бүрдүүлэхэд баримтлах журам”-ын 2.1.3-д заасан төслийн шимтгэлийн хувийг МУИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн дансад төлсөн байх.
- 4.3.5. жил бүр эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн үр дүнг Эрдэм шинжилгээний мэдээллийн менежментын систем (цаашид “ЭШММС” гэх), Төслийн мэдээллийн менежментийн систем (цаашид “ТММС” гэх)-д бүртгүүлэх;
- 4.3.6. явцын тайлан, үр дүнг улирлаар, хагас жилээр, эцсийн тайланг ТММС-д бүртгүүлэх;
- 4.3.7. улирал, хагас жилийн явцын үнэлгээнд үндэслэн үйл ажиллагаагаа сайжруулах, хөрөнгө зардлыг зориулалтын дагуу үр өгөөжтэй зарцуулах;
- 4.3.8. төслийг хугацаанд нь багтааж бүрэн гүйцэтгэх, үр дүнг тоо, чанарын хувьд анх төлөвлөсөн түвшнээс бууруулахгүйгээр хүлээлгэн өгөх;
- 4.3.9. төслийн үр дүнг сурталчлах, борлуулах талаар санаачлага гарган ажиллах;
- 4.3.10. төслийн тайлан, бүтээлийг өөрийн ажил (original work) мөн гэдгийг баталж зохиогчийн эрхээ баталгаажуулах;
- 4.3.11. төслийн хүрээнд худалдан авсан багаж, техник хэрэгсэл, ном, сэтгүүлийг МУИС-ийн эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх.
- 4.4. Судалгааны туслах ажилтны эрх, үүргийг “МУИС-ийн магистрант, докторантыг туслахаар ажиллуулах журам”-ын 4-р зүйлд заасны дагуу зохицуулна.

4.5. МУИС-ийн судлаачийн судалгааны ажлын гүйцэтгэх ажлын даалгавар, төлөвлөгөө, хугацаа, хөдөлмөрийн нөхцөл зэрэг харилцааг талууд харилцан тохиролцож Хөлсөөр ажиллах гэрээгээр зохицуулна.

4.6. МУИС-ийн судлаачийн судалгааны ажлын ачааллыг ЭШММС-д Маягт 1, ТММС-д Маягт 2-д заасан аргачлалаар тооцож бүртгүүлнэ.



ТАВ. Цалин хөлс, тэтгэлэг тооцох

5.1. ЭША-ны цалингийн хэмжээг Засгийн газрын " Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" тогтоолыг үндэслэн тогтооно.

5.2. МУИС-ийн судалгааны хүрээлэн, төвийн судлаачийн цалинг МУИС-д мөрдөж буй цалингийн сүлжээний дагуу албан тушаалын зэрэглэлийн холбогдох шатлалаар тогтооно.

5.3. МУИС-иас өөр санхүүжилттэй төслийн судлаачийн хөлсийг МУИС-ийн цалингийн сүлжээг баримтлан судалгааны ажлын ачаалалд үндэслэн тогтооно.

5.4. Докторын дараах тэтгэлгийг "МУИС-д пост-доктор ажиллуулах журам"-д заасны дагуу тогтооно.

5.5. Судалгааны туслах ажилтны тэтгэлэгийг "МУИС-ийн магистрант докторантыг туслахаар ажиллуулах журам"-д заасан холбогдох заалтыг үндэслэн тогтооно.

ЗУРГАА. Бусад зүйл

6.1. МУИС-ийн ЭШХ нэгж, ЗХНХ нэгж, СТХ нь ШУТ 1-8 статистик мэдээг жил бүрийн 02-р сарын 20-ны дотор Маягт 1, 2-д заасан аргачлалд үндэслэн боловсруулж Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүлээлгэж өгнө.

Маягт 1. Судлаачийн БЦАХТШУ-г тооцох аргачлал¹.

a* - Хагас цагийн жин (судалгаанд)

b**- Хүн-жил

c*** - Зарцуулсан ажлын цагийн эзлэх жин



| Албан тушаалын зэрэглэл, үндсэн ажил | А Бб ц | Б Бб ц | В Бб ц | a | Ажилласан хугацаа (сар) | b** | Зарцуулсан ажлын цагийн хувь (%) | c*** | БЦАХТШУ (a x b x c) | Хүний тоо | Нийт БЦАХТШУ |
|--------------------------------------|--------|--------|--------|------|-------------------------|------|----------------------------------|------|---------------------|-----------|--------------|
| Профессор | 12 | 10 | 4 | 0.38 | 12 | 1.00 | 90 | 0.90 | 0.34 | 1 | 0.34 |
| Дэд профессор | 13 | 8 | 5 | 0.31 | 12 | 1.00 | 90 | 0.90 | 0.28 | 2 | 0.56 |
| Ахлах багш | 15 | 6 | 5 | 0.23 | 12 | 1.00 | 90 | 0.90 | 0.21 | 2 | 0.41 |
| Багш | 16 | 5 | 5 | 0.19 | 12 | 1.00 | 90 | 0.90 | 0.17 | 1 | 0.17 |
| Докторант (судалгааны туслах) | 8 | 12 | 0 | 0.60 | 12 | 1.00 | 90 | 0.90 | 0.54 | 4 | 2.16 |
| Магистрант (судалгааны туслах) | 30 | 0 | 0 | 0.40 | 12 | 1.00 | 70 | 0.70 | 0.28 | 4 | 1.12 |
| ЭША | 0 | 0 | 0 | 1.00 | 12 | 1.00 | 90 | 0.90 | 0.90 | 1 | 0.90 |
| Нийт | | | | | | | | | | 15 | 5.66 |

¹ 1 Профессор, 2 дэд профессор, 2 ахлах багш, 1 багш, 4 докторант, 4 магистрант, 1 ЭША нийт 15 судлаач ажиллаж буй судалгааны хүрээлэн, төвийн БЦАХТШУ тооцсон жишээ: профессор нийт 26 Ббц-аас 10 Ббц судалгаанд зарцуулж, 10.5 сар ажиллаж, 1.5 сар амарсан байна.

БЦАХТШУ-н тооцоо:

$$a = 10:26 = 0.38$$

$$b = 1 \text{ хүн-жил}$$

$$c = 10.5:12 = 0.9$$

Иймд, профессорын судалгааны БЦАХТШУ = a x b x c = 0.34 байна.

Маягт 2. Төсөл дээр ажиллаж буй судлаачийн БЦАХТШУ тооцож ТММС-д бүртгэх аргачлал.

Бүтэн орон тооны судлаач:

1. судалгааны ажилдаа нэг жилд цагийн 100% зарцуулж буй тохиолдолд: $(1 \times 1 \times 1) = 1$ БЦАХТШУ;
2. нэг жилд ажлын цагийн 30 %-г зарцуулж буй тохиолдолд: $(1 \times 1 \times 0.3) = 0.3$ БЦАХТШУ;
3. судалгааны ажилдаа өөрийн цагийн 100% -ийг зарцуулж байгаа ба нийт 6 сар ажиллах тохиолдолд: $(1 \times 0.5 \times 1) = 0.5$ БЦАХТШУ;
4. нэг жилд 6 сар судалгааны үйл ажиллагаанд 40 % -иар ажиллаж буй тохиолдолд: $(1 \times 0.5 \times 0.4) = 0.2$ БЦАХТШУ;
5. 20 бүтэн орон тооны судлаач нэг жилд өөрийн цагийн 40 %-ийг судалгаанд зарцуулж буй тохиолдолд: $20 \times (1 \times 1 \times 0.4) = 8$ БЦАХТШУ байна

Хавсран гүйцэтгэгч судлаач:

6. нэг жилд 40% -иар ажилладаг судлаач жилийн туршид зөвхөн судалгааны ажил хийж буй тохиолдолд (өөрийн цагийн 100%-ийг судалгаа, боловсруулалтандаа зориулж байна): $(0.4 \times 1 \times 1) = 0.4$ БЦАХТШУ²;
7. 40%-иар бүтэн жилд судалгаанд ажлын цагийн 60%-ийг зарцуулахдаа 6 сар ажиллаж буй тохиолдолд: $(0.4 \times 0.5 \times 0.6) = 0.12$ БЦАХТШУ;

² Магистрант нэг жилд 40% -иар ажилладаг судлаач ба тэрээр жилийн туршид зөвхөн судалгааны ажил хийж буй тохиолдолд (өөрийн цагийн 100%-ийг судалгаа, боловсруулалтандаа зориулж байна) түүний БЦАХТШУ тооцсон жишээ.